



## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 571

Улаанбаатар хот

### Д.Энхболдод сахилгын шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.2, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Монгол Улсын сайд-Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журмын 5.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны А/211 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журмын 10.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын Бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Дамдиндоржийн Энхболд нь үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийг хөтлөхдөө Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн энгийн гадаад паспорт, ... авахдаа дараах баримт бичгийг бүрдүүлж өөрийн биеэр бүртгүүлнэ”, Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 9.2 дахь заалтад “Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл хөтлөхөд 16-аас дээш насны иргэний биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл, ...-д үндэслэнэ” гэж заасныг зөрчин албан үүрэгтээ хариуцлагагүй хандсан нь Нийслэлийн прокурорын газрын 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 35 дугаар Прокурорын тогтоол, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 02 дугаар Мөрдөгчийн мэдэгдэл, өөрийн өгсөн тайлбараар тогтоогдсон тул албан тушаалын цалингийн хэмжээг 2020 оны 6 дугаар сарын 11-ний өдрөөс 6 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч Д.Энхболдод үүрэг болгосугай.

3.Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Бүртгэлийн хэлтэс /Б.Байгалмаа/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Б.БААСАНДОРЖ

571002091